

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН**



Шинэ номын мэдээ

2018.03.13

№ 01

Эмхтгэсэн: Ном зүйч У.Гэрэлтуяа

Ном зүйч С.Найгалмаа

**Электрон каталоги:
<http://catalog.num.edu.mn>**

ГАРЧИГ

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-4
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4
ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ АХУЙ.....	5
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	5-8
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	9-12
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	12-16
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	16-18
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	18-20
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН. ГЭГЭЭРЭЛ.....	20-21
БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ УХААН.....	21-22
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	22-25
УРАН ЗОХИОЛ.....	26-27
УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....	27-28
ШАШИН СУДЛАЛ.....	28-29
ГҮН УХААНЫ ШИНЖЛЭХ УХААН.....	29-30
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	30-31
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ.....	31-33

Товчилсон үгийн тайлбар:

БУН унш-Байгалийн ухааны номын уншлагын танхим	/306 тоот/
НУН унш-Нийгмийн ухааны номын уншлагын танхим	/211 тоот/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд	/109, 110 тоот/
ЭШФ-Эрдэм шинжилгээний фонд	/411 тоот/
ГФ-Гадаад номын фонд	/411 тоот/
БС-Бизнесийн сургууль	/Хич-V байр 505 тоот/
ХЗС-Хууль зүйн сургууль	/Хич-III байр 205 тоот/
ОУХНУС-Олон улсын харилцаа. Нийтийн удирдлагын сургууль	/Хич-V байр №304 тоот/

БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН



Тэрбиш Х., Адъяа Я. **Экологи**: Их дээд сургууль, коллежийн оюутан, байгаль хамгаалагчдад зориулав / Хян. Ц.Жамсран.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 162х.- ISBN 978-99929-833-2-9.

Экологийн ухааны судлах зүйл, зорилт, экологийн хүчин зүйл, түүний амьд биед үйлчлэх үндсэн зүй тогтол, биологийн бус хүчин зүйл, организмын дасан зохицол, амьдралын үндсэн орчин, популяцийн экологи, экосистем, биосфер зэрэг экологийн ухааны үндсэн асуудлыг энэ номонд тусгасан

болно.

20.1

T-92

ЭШФ T-20642-20643

Тунгалаг Л. **Математик-2** / Ред. С.Будням.- УБ.: Линограф, 2016.- 402х.- ISBN 978-99962-932-8-3.



Энэхүү сурах бичгийг математикийн курсуудын материал, өөрийн болон бусад орны эрдэмтдийн бичсэн сурах бичиг, гарын авлага, холбогдох материалыг ашиглан МУИС-д баримталж байгаа сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу бэлтгэжээ. Уг номыг шугаман алгебр, аналитик геометр, дифференциал тоолол, интеграл тоолол, дифференциал тэгшитгэл, олон хувьсагч бүхий функц зэрэг математикийн үндсэн хичээлүүдийн хөтөлбөртэй уялдуулан бичсэн байна. Мөн тухайн бүлэг сэдэвтэй холбоотой мэдлэгийг онолоор бататган, бие дааж бодох бодлогыг бодож тайлбарласан ба нэр томъёоны тайлбар, ном зүй, хавсралт зэргийг багтааж математик, инженерийн математик хичээлийг судалж буй оюутнуудад зориулжээ.

22.1я73

T-67

/БУН унш-3ш, Цахим ном/

ЭШФ Б-28081-28082



Батсүх Г. **Механик хөдөлгөөний кинематик** / Хян. Ц.Баатарчулуун, Р.Бавуудорж.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 100х.- ISBN 978-99978-0-690-1.

Манай улс ЕБС-ийн сурагчдын дунд байгалийн ухааны олон салбараар янз бүрийн хэлбэрээр уралдаан тэмцээн зохион байгуулдаг бөгөөд энэхүү гарын авлагыг Монголын физикийн 30-р олимпиадыг угтан гаргажээ. Тус гарын авлага нь ерөнхий боловсролын сургуулийн багш болон сурагчид, оюутнуудад зориулагдсан ба сэдэв бүрийн төгсгөлд мэдлэгээ бататгах

дасгал бодлого оруулсан болно.

22.2

Б-34

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ T-20872-20874

ХАТУУ БИЕИЙН ФИЗИК

Алтанцог П. **Монгол орны шилний түүхий эд, шилний шинж чанар** / Ерөн. ред. Ш.Чадраабал.- УБ.: Адмон принтинг, 2017.- 183х.- ISBN 978-99978-1-710-5.



Шил бол аж үйлдвэрийн олон салбарт төрөл бүрийн бүтээгдэхүүн хийдэг орчин үеийн нэн чухал материал юм. Энэхүү номонд төрөл бүрийн түүхий эдийг боловсруулах, шил хайлах, цутгах, хэвлэх, нэмэлт боловсруулалт хийх, шилний гол гол физик шинж чанарыг хэмжих, хөөсөн шил гарган авах судалгаа, элсийг ашиглан шил хийх технологийн талаар мөн ШУА-ийн ФТХ-д сүүлийн 20 орчим жил шилний талаар хийсэн эрдэм шинжилгээ, боловсруулалтын ажлын гол гол үр дүнг багцлан бичсэн байна.


22.37+35

А-48

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-20866-20868

ОДОН ОРОН СУДЛАЛ



Астрономи / Д.Баасанжав, Г.Даваахүү, Д.Лхагвасүрэн ба бус.; Хян. Д.Лхагвасүрэн.- УБ.: Сэлэнгэпресс, 2016.- 292х.- (ШУА-ийн Одон орон, Геофизикийн Хүрээлэнгийн Астрометрийн сектор).- ISBN 978-99973-912-6-1.

Астрономи нь орчлон, түүний дотор орших биетүүдийн тогтоц, бүтэц хөгжлийн ерөнхий хууль, зүй тогтлыг судалдаг шинжлэх ухаан бөгөөд энэ номонд тэнгэр эрхсийн байрлал, үзэгдэх хөдөлгөөн, цаг хугацааны хэмжил, дэлхийн туйл, нарны аймаг, од түүний физик шинж чанар, галактик, орчлон түүний хувьслын талаар нийт сонирхогч, уншигчдад тодорхой ойлголт өгөхийг зорьжээ.


22.6

А-83

/БУН унш-3ш/

ЭШФ Т-21015-21016

Астрономийн товч тайлбарт толь-лавлах бичиг / Эмхт. Д.Баасанжав; Ред. Д.Батмөнх, С.Дэмбэрэл, Ч.Лхагважав, Д.Лхагвасүрэн.- УБ.: Адмон принт, 2017.- 384х.- ISBN 978-99978-900-0-9.



Астрономи бол нэн эрт дээр үед үүсч, эдүгээ тасралтгүй хөгжсөөр ирсэн ууган шинжлэх ухаан бөгөөд орчин үеийн астрономи, сансар судлалын талаархи мэдлэгийн эрэлт хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үед астрономийн үзэгдэл юмсын нэршил, зүй тогтол, нэр томъёоны утга агуулгыг тайлбарласан энэхүү лавлах бичгийг бүтээн, сансар судлал сонирхогчид, эрдэмтэн судлаачид, оюутан нарт толилуулж байна.

22.6я2

А-83

/БУН унш-7ш/

ЭШФ Т-21017-21019



2016 оны астрономийн цаглабар №8 / Эмхт. Д.Баасанжав; Ред. Д.Батмөнх, С.Дэмбэрэл, Ч.Лхагважав, Д.Лхагвасүрэн.- УБ.: Сэлэнгэпресс, 2015.- 184х.- (ШУА-ийн Одон орон, Геофизикийн Хүрээлэн).

Энэхүү цаглабарт орчлон, одны ай, од, нар, сар, гаригуудын тухай товч ойлголт, тэдгээрийн тухайн өдөрт харгалзах солбицол, нар, сарны хиртэл зэрэг үзэгдлүүдийг хэзээ хаана ажиглаж болох тухай бусад лавлагааны чанартай өгөгдөхүүнүүдийг оруулав.

22.6

X-40

/БУН унш-3ш/

ЭШФ Т-21009-21010

2017 оны астрономийн цаглабар №9 / Эмхт. Д.Баасанжав; Ред. Д.Батмөнх, С.Дэмбэрэл, Ч.Лхагважав, Д.Лхагвасүрэн.- УБ.: Сэлэнгэпресс, 2016.- 158х.- (ШУА-ийн Одон орон, Геофизикийн Хүрээлэн).- ISBN 978-99978-4-132-2.



Энэхүү цаглабарт орчлон, одны ай, од, нар, сар, гаригуудын тухай товч ойлголт, тэдгээрийн тухайн өдөрт харгалзах солбицол, нар, сарны хиртэл зэрэг үзэгдлүүдийг хэзээ хаана ажиглаж болох тухай бусад лавлагааны чанартай өгөгдөхүүнүүдийг оруулав.

22.6

X-40

/БУН унш-3ш/

ЭШФ Т-21011-21012



2018 оны астрономийн цаглабар №10 / Эмхт. Д.Баасанжав; Ред. Д.Батмөнх, С.Дэмбэрэл, Ч.Лхагважав, Д.Лхагвасүрэн.- УБ.: Адмонпринт, 2017.- 172х.- (ШУА-ийн Одон орон, Геофизикийн Хүрээлэн).

Энэхүү цаглабарт орчлон, одны ай, од, нар, сар, гаригуудын тухай товч ойлголт, тэдгээрийн тухайн өдөрт харгалзах солбицол, нар, сарны хиртэл зэрэг үзэгдлүүдийг хэзээ хаана ажиглаж болох тухай бусад лавлагааны чанартай өгөгдөхүүнүүдийг оруулав.

22.6

X-40

/БУН унш-3ш/

ЭШФ Т-21013-21014

ФИЗИКИЙН ХИМИ. ХИМИЙН ФИЗИК

Сарангэрэл Д., Алтангэрэл А. **Физик химийн бодлогын эмхэтгэл:** Бодолтын ном / Ред. Д.Сарангэрэл.- 1 дэх хэвл.- УБ.: Адмон, 2017.- 309х.- ISBN 978-99978-0-771-7.



Энэхүү номыг их сургууль, коллежийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн химийн багш нар, гүнзгийрүүлсэн сургалттай ангийн сурагчид, химийн олимпиадад бэлтгэгчдэд зориулав.


24.5я7

С-33

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-19242-19244

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Дариймаа Ш., Саруул Н. **Монголын ургамлын аймаг:** 146 дэвтэр / Ред. Э.Ганболд.- УБ.: Удам соёл, 2017.- 220х.- (Шинжлэх Ухааны Академи. Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн. Ургамлын аймаг ангилал зүйн лаборатори).- ISBN 978-99929-78-15-5.


Энэ цуврал бүтээлд 39 төрөлд хамаарах 144 зүйл ургамлын төрөл, зүйлийн таних түлхүүр, триб, дэд трибын ялгагдах шинж, төрөл, зүйлийн шинж, ургах орчин, ерөнхий болон монгол дахь тархацыг ургамал газар зүйн 16 тойргийн хэмжээнд, мөн баг цэцэг, цэцгийн суудал, хэл, хоолой цэцгийн бүтэц, дохиур, шинээр тэмдэглэсэн дохиурын онцлог, үр боловсрох орны амсар, үр жимс, тоос, навчны бариулын хөндлөн огтлолын зургуудыг оруулсан болно.

28.5(1)

Д-36

ЭШФ Т-20982-20984

Хуруу шилэн доторх ургамал-2: Гарын авлага / Ю.Оюунбилэг, Х.Алтанзул, Б.Ганбат ба бус.; Ред. Ю.Оюунбилэг, Б.Оюунцэцэг.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 120х.- ISBN 978-99978-1-506-4.



Энэхүү номонд Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Ургамлын биотехнологийн лабораторийн хамт олны сүүлийн жилүүдэд хийсэн Монгол орны зарим устаж, ховордож буй эмийн ургамлын эд эсийн өсгөврийн туршилт судалгааны үр дүнгийн талаар өгүүлжээ. Эл номыг материал, арга зүй, гүйцэтгэл, үр дүн, хэлэлцүүлэг, дүгнэлт, ном зүй гэсэн дарааллаар бичсэн бөгөөд цаашид судалгаа хийх залуу судлаачид, оюутан, тухайн чиглэлээр суралцаж буй магистрант, доктрант, мэргэжилтнүүдэд лабораторид бие даан туршилт, судалгааны ажил хийхэд гарын авлага болгон ашиглах боломжтой юм.

28.53

Х-73

/БУН унш-5ш/

ЭШФ Т-20869-20871

ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ АХУЙ



Хөдөө аж ахуйн мэргэд: Боть-1: Бадамын Яримпил / Эмхт. Я.Ариунчимэг, Я.Ариунбаатар, Я.Ариунбат, А.Жавхлан; Ред. Ч.Тунгалаг.- УБ.: Наранбулаг Принтинг, 2016.- 271х.- ISBN 978-99973-907-6-9.

Монгол орны хөдөө аж ахуйн салбарт орчин цагийн шинжлэх ухааныг хөгжүүлэх болон ХААИС-ийг үүсгэн байгуулагчдын гавьяат үйлсийг мөнхжүүлэх үүднээс “Хөдөө аж ахуйн мэргэд” цуврал бүтээлийг санаачилж байгаа бөгөөд анхны ботийг үе үеийн шавь нарынхаа дунд “Яа” багш хэмээгдэж ирсэн профессор Б.Яримпил багшийн 100 насны ойг тохиолдуулан гаргаж байна. Энэхүү номоос ахмад эрдэмтэн профессор Б.Яримпилийн хийж байсан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, боловсруулсан заавар зөвлөмж, бэлтгэсэн мал эмнэлгийн микробиологи, халдварт өвчний хичээлийн сурах бичиг, лекц, дадлагын ажил нь одооч үнэ цэнээ алдаагүй болохыг мэдэх болно.

40г

X-55

ЭШФ Т-19313

Мэндсайхан З. ба бус. **Эмт ургамал:** Боть-1, 2 / З.Ариунаа, М.Пүрэвжав; Ерөн. ред. У.Лигаа; Ред. Д.Ганзориг.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.



Уг номонд уламжлалт жоронд ордог 300 гаруй ургамлын зүйл, тэдгээрийн 1500 гаруй төлөөлөл болсон эмт ургамлын талаарх уламжлалт анагаах ухааны эртний судруудын ойллого болон орчин үеийн шинжлэх ухааны судалгааны материалаас тоймлон өгүүлжээ. Мөн Монгол оточ нарын өнөө болтол хэрэглэж ирсэн эмт ургамлуудын өнгөт зураг, тайлбарыг тодотгол болгон оруулж, эмт ургамлын орон орны ардын болон уламжлалт эмнэлэг, орчин үеийн анагаах ухаан дахь хэрэглээг дурдснаас гадна өргөн хэрэглэдэг зарим уламжлалт эм, тангуудын нэршил, зураг, хэрэглэх заавар, “Монг-Эм” ХХК-иас санхүүжүүлэн сүүлийн 5 жилд зохион байгуулсан Монгол орны эмт ургамлын нөөц, тархалт, тандалт экспедицийн зургийг хавсаргажээ.

42.143

M-96

Боть-1: 451х.- ISBN 978-99973-66-75-7. /БУН унш-7ш/ ЭШФ Т-19295-19297

Боть-2: 410х.- ISBN 978-99973-66-75-7. /БУН унш-7ш/ ЭШФ Т-19298-19300

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Смит Н. **Чөлөөт нийгмийн зарчмууд** / Орч. Ц.Пүрэвтүвшин; Хян. Ч.Өнөрбаяр.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 261х.- (“Эрх зүйт ёс” сан).- ISBN 978-99973-3-574-6.

Зохиогч энэхүү номондоо чөлөөт нийгмийн 12 зарчмыг томьёолж, тэдгээрийн академик утгыг хамгийн сонгодог төвшинд маш товчоор, илүү

дутуу үггүйгээр тайлбарласан байна. Тэрээр чөлөөт нийгэмд нийгмийн гэрээ хэрхэн хэрэгждэгийг, бидний нийгмийн гэрээний онолын талаарх академик мэдлэгийг нийгмийн үзэгдэлтэй гайхалтай холбожээ.


60

C-48

/ОУХНУС-2ш/

Mongolica: An international journal of Mongol studies: Vol.1(45) / Ред. Д.Төмөртоого.- УБ., 2012.- 226х.- ISSN 1024-3143.


Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг цуврал хэвлэлийн энэ дугаарт монгол хэл шинжлэл, түүх, ёс заншил, зан үйлийн талаар бичсэн монгол судлаач, эрдэмтдийн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тэмдэглэлүүд орсон байна.



60(1)

M-81

ЭШФ Т-20668



Mongolica: An international journal of Mongol studies: Vol.46 / Ред. Д.Төмөртоого.- УБ., 2013.- 242х.- ISSN 1024-3143.

Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг цуврал хэвлэлийн энэ дугаарт монгол хэл шинжлэл, уран зохиол судлал, түүх, соёл иргэншлийн тухай эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүд орсон байна.

60(1)

M-81

ЭШФ Т-20669

Mongolica: An international journal of Mongol studies: Vol. 47 / Ред. Д.Төмөртоого.- УБ., 2014.- 214х.- ISSN 1024-3143.


Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг цуврал хэвлэлийн энэ дугаарт монгол хэл шинжлэл, уран зохиол судлал, түүх, соёл иргэншил сэдвээр монгол судлаач, эрдэмтдийн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тэмдэглэл оржээ.

60(1)

M-81

ЭШФ Т-20670





Mongolica: An international journal of Mongol studies: Vol.48 / Ред. Д.Төмөртогтоо.- УБ., 2015.- 268х.- ISSN 1024-3143.

Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг цуврал хэвлэлийн энэ дугаарт монгол хэл шинжлэл, уран зохиол судлал, түүх, соёл иргэншил сэдвээр монгол судлаач, эрдэмтдийн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүд орсон байна.

60(1)
М-81

ЭШФ Т-20671

Нийгмийн халамжийн ажлын үндэс: Нийгмийн ажилтнууд, оюутан, суралцагчдад зориулав / И.Сү жин, Хуан Гён Ран, Т.Намжил, Б.Сүх-Очир; Ред. Б.Сүх-Очир, Ц.Энхтүвшин.- УБ.: Битпресс, 2014.- 148х.- ISBN 978-99973-67-75-4.

Энэхүү хамтын бүтээлд Нийгмийн халамжийн үндсэн ойлголт, онол арга зүйн хийгээд халамж үйлчилгээний чиглэл онцлогийг тодорхойлон оруулснаар энэ чиглэлээр ажиллагсад, оюутан суралцагсад нийгмийн халамжийн талаар дэлхийн хөгжингүй орны түвшинд мэдлэг мэдээллийг авах боломжтой.



60.54
Н-58

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-20897-20899



Уртнасан Ц. **Монголын нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ** / Хян. Ц.Цэцэнбилэг, Ж.Батжаргал; Эмхт. О.Баасантогтох, Ё.Ундрал, Ж.Пүрэвханд.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 363х.- (Бүтээлийн эмхтгэл).- ISBN 978-99978-0-561-4.


Энэхүү бүтээл нь 2 үндсэн хэсэг, хавсралтаас бүрджээ. Эхний хэсэгт доктор Ц.Уртнасангийн эрдэм шинжилгээний гол бүтээлүүд, 2 дахь хэсэгт багшийн 70 насны ойд зориулан зохион байгуулж буй “Монголын нийгмийн бүтцийн судалгаа, шинжилгээ” симпозиумын илтгэлүүдийг нийтэлжээ. Үүнээс гадна Монголын социологийн хөгжлийн түүхэн тойм, социологийн судалгааны арга зүй, аргачлалыг хэрхэн хөгжүүлэх, сайжруулах онол арга зүйн бичвэрүүд болон нийгмийн хөгжлийн учир шалтгаан, зүй тогтлыг шинжилсэн судалгааны өгүүлүүд, судалгааны тайлангийн хэсгүүдийг оруулсан байна.

60.55(1)
У-51

/НУН унш-3ш/

ЭШФ Т-19281-19283

Монголчууд социологийн судалгаанд... Судалгааны эмхэтгэл: Цуврал IV: Монгол, англи, орос хэл дээр / Ред. Ц.Уртнасан, Ц.Цэцэнбилэг, Ж.Батжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2015.- 182х.- ISBN 978-99973-78-97-2.



Уг товхимолд ШУА-ийн ФСЭХ-ийн Социологийн салбараас (тухайн үеийн нэрээр) 2005-2012 онд явуулсан суурь болон хавсарга нийт 8 судалгааны үр дүнгээр Монголчуудын талаарх ерөнхий зураглалыг 5 багц сэдвийн хүрээнд авч үзэн Монголчуудын сэтгэл санаа, оюун бодлын дотоод ертөнцөөр аялахын зэрэгцээ түүнд гарч буй өөрчлөлтийг танин мэдэх, судлах боломж олгох юм. Эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагч, төрийн албан хаагчид, оюутан сурагчид, социологи, нийгмийн сэтгэл зүйг сонирхогч хэн бүхэнд зориулагдсан уг бүтээл судалгааны талаарх шаардлагатай товч мэдээлэл, график шинжилгээ, илүү өргөн цогц мэдээлэл агуулснаараа онцлогтой юм.

60.56

М-69

/НУН унш-3ш, ГНОФ-2ш/

ЭШФ Т-19279-19280



НИЙГМИЙН
АЖИЛ



Нийгмийн ажил: Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг / Г.Түмэннаст, М.Батбаатар, А.Батхишиг ба бус.; Ерөн. ред. Г.Түмэннаст.- УБ.: МУИС Пресс, 2017.- 284х.- ISBN 978-99978-58-15-3.


МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш нар мэргэжлийн удиртгал мэдлэгийг багтаасан "Нийгмийн ажил" сурах бичгийг уншигч танаа толилуулж байна. Энэ сурах бичиг нь ерөнхий эрдмийн суурь хичээлийн хүрээнд тус тэнхмийн багш нараас удирдан явуулдаг "Нийгмийн ажил" хичээлийг сонгон судалж буй оюутнуудад зориулсан мэргэжлийн үндсэн асуудлуудыг багтаажээ.

60.56я73

Н-58

/ОУХНУС-1ш/

Монгол дахь хотжилт: Үйл явц, төлөв байдал / Ред. Ц.Цэцэнбилэг, Ц.Пүрэв, Ж.Батжаргал.- УБ.: Тод бичиг, 2014.- 288х.- ISBN 978-99973-945-7-6.



XX зууны эхэн үеэс Монголчууд суурьшмал амьдралд шилжих үйл явц эхэлж, улсын нийт нутаг дэвсгэрийг засаг захиргааны нэгжүүдэд хуваах зэргээр хот суурин газрын суурь тавигдсан байна. Энэхүү номонд хотын талаарх ойлголт, Монгол дахь хотжилтын үйл явц, хотын хүн амын амьдралын хэв маяг, хотын соёл, хот төлөвлөлт зэргийг тусгажээ. Мөн 2012 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын 1400 оршин суугчдын дунд явуулсан социологийн судалгааг оруулжээ.

60.7(1)

М-69

/НУН унш-4ш/

ЭШФ Т-19284-19285

ТҮҮХ, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Лонжид З. **Түүх сурахуй**. - УБ.: Маршал Принт, 2016.- 422х.- ISBN 978-99973-49-82-8.

Энэхүү номонд 1993-2016 оны хооронд бичсэн түүхийн судалгааны өгүүлэл, тэмдэглэл, эргэцүүлэлийг эмхэтгэн хэвлүүллээ. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч хэн бэ?, Богд хаантны улс төрийн үйл ажиллагааг нэхэн судлахын учир, Гадаад Монголын автономит эрхийг хэвээр үлдээхийг хүсч Богд хаантнаас Иргэн улсын Да жүнтүнд илгээсэн захидал, VIII Богдын хойд дүр ба улаантнууд, Монгол улсын Ардын засгийн газрын бүрэн эрх барих төлөөлөгчийн тамга, Монголын түүхчид сайд Цэрэнчимэдийн тухай судалсан байдлын тойм, Х.Чойбалсан ба мал сүрэг зэрэг түүхийн эргэцүүлэлүүдийг эмхэтгэн оруулжээ.

63.3(1)

Л-75

ЭШФ Т-19312

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга: Олон улсын эрдэм шинжилгээний II хурал: Илтгэлүүдийн эмхтгэл / Ред. эмхт. Д.А.Носов, В.Ю.Жуков, Л.Г.Скородумово; Хариуцлагатай ред. С.Чулуун.- УБ.: Адмонпринт, 2017.- 263х.- ISBN 978-99978-854-0-1.



Эмхтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны өнөөгийн байдал, нэрт Монгол судлаачдын амьдрал, үйл хэрэг хийгээд монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, эх хэрэглэгдэхүүний талаар өгүүлсэн илтгэлүүд багтсан.

63.3(1)

М-69

ЭШФ Т-19245-19247



Олон улсын Монголч эрдэмтдийн X их хурлын илтгэлүүд: Боть-1-5 / Ред. Д.Төмөртоого.- УБ., 2012.

Олон улсын Монголч эрдэмтний X их хурлын 5 салбар хуралдаанд тавигдсан Монголын түүх, соёл, улс төр, эдийн засаг, тусгаар тогтнол, гадаад харилцааны чиглэлээр дотоодын болон гадаадын олон судлаач, эрдэмтдийн тавьсан илтгэлүүдийг бүрэн эхээр нь эмхэтгэн оруулжээ.

63.3(1)+72

О-72

Б.1: I салбар хуралдаан: Түүхийн өмнөх үе болон түүхэн үеийн Монгол ба гадаад ертөнц.- 356х. ЭШФ Т-20660

Б.2: II салбар: Монгол хэл, соёлын тулгамдсан асуудлууд.- 431х.

ЭШФ Т-20661

Б.3: III салбар: Монголын эдийн засаг, улс төр.- 263х.

ЭШФ Т-20662

Б.4: IV салбар: Монголын гадаад харилцаа, дипломат ёс.- 223х.

ЭШФ Т-20663

Б.5: V салбар: Монголын тусгаар тогтнол, хувьсгал.- 207х.

ЭШФ Т-20664

Алтангүл Б. **Францын Монгол судлал**: Эрдэмтдийн товч намтар, бүтээлийн жагсаалт / Ред. Г.Буяннэмэх.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 106х.- ISBN 978-99978-2-114-0.




Францын Монгол судлаачид Европ тивд Монгол судлалын салбар хөгжихөд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ба эхний үед хэл шинжлэл, түүх, соёл, заншил, бөөгийн зан үйлийг түлхүү судалдаг байсан бол өнөөдөр орчин үеийн бүхий л салбарыг судалж байна. Францын Монголч эрдэмтдийн товч намтар, судалгааны чиглэл болон нэг сэдэвт, гол бүтээлүүдийг энэхүү бүтээлээрээ хүргэж байна.

63.3(1)г

А-48

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20985-20987



Уэтерфорд Ж. **Монголын их хатдын нууц товчоо**: Чингис хааны эзэнт гүрнийг охидууд нь аварч хамгаалсан түүх / Орч. А.Мөнгөнзул, С.Соёлжин; Хян. Б.Наминчимэд.- 3 дахь хэвл. - УБ.: Grown publishing, 2016.- 254х.- ISBN 978-99962-1-225-3.

Энэ ном нь “Чингис хааны охид байгаагүйсэн бол Монголын эзэнт гүрэн өнө удаанаар оршин тогтнож чадахгүй байсан” түүхийн нарийн эмзэг нууцыг бидний өмнө нээж буй төдийгүй Чингис хааны тэдгээр охидоос эхлээд Монгол төрийн гал голомт унтран бөхөж байх эгзэгтэй мөчид садарсан үсээ шууж, саадаг нум үүрч босон, тэмцсэн Мандухай сэцэн хатныг хүртлэх түүх домогт их хатдын яруу алдарт амьдралын тухай өгүүлжээ.

63.3(1)42

У-69

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-19256-19258

Чулуун С. **Монгол улсын анхны ерөнхий сайд Оросын эзэнт улсад**: Түүх-гэрэл зураг / Ред. Д.Өлзийбаатар.- УБ.: Адмон принт, 2014.- 112х.- ISBN 978-99973-0-453-7.



Энэхүү товхимолд Монгол улсын анхны ерөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэнгийн Оросын эзэнт улсад 1913 оны 10-р сараас 1914 оны 2 сар хүртэлх хугацаанд хийсэн төрийн айлчлалтай холбоотой баримт, эх хэрэглэгдэхүүнээс гадна айлчлалын үед авахуулсан урд өмнө хэвлэлд нийтлэгдээгүй хуучны гэрэл зургууд, захидал бичиг, сонин хэвлэлд нийтлэгдэж байсан зарим баримтууд оржээ. Монгол улсын анхны ерөнхий сайд, Сайн ноён хан Төгс-очирын

Намнансүрэнгийн Оросын эзэнт улсад төрийн айлчлал өндөрлөсөн түүхт 100 жилийн ойд зориулан хэвлүүлсэн энэхүү ном нь XX зууны эхэн үеийн Монголын түүх, гадаад харилцааг судлаач, сонирхогчдад гарын авлага болох ажээ.

63.3(1)52

Ч-89

ЭШФ Т-19314-19316



Батбилиг Б. **Миний ертөнц** / Ред. Д.Баттогтох, Ч.Чойсамба.- УБ.: Арвай Бархан ХХК, 2017.- 350х.- ISBN 978-99978-0316-0.

Экологийн сэтгүүл зүйн амьд нэвтэрхий толь хэмээн шавь нартаа өргөмжлөгдсөн сэтгүүлч багш маань энэ номондоо монголын улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль, экологийн сэдвээр бичсэн, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, нийтлэл, сурвалжлага, Германд суралцсан он жилүүд, Халим судлалын ОУ-ын багт ажиллаж Номхон далайгаар аялсан тэмдэглэл мөн бага залуу насны дурсамж, хамт олон, анд нөхөд, шавь нарынхаа талаар хүүрнэсэн өгүүлэмж, сэлтийг дээжлэн оруулжээ.

63.3(1)6-8

Б-33

ЭШФ Т-19251-19253

Цэрэндагва Я., Цэвээндорж Д. **Далан түргэний хос толгойн хадны зураг** / Ред. Д.Цэвээндорж.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 425х.- ISBN 978-99973-0-769-9.


Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Хотон нуурын савд орших Далан Түргэний хос толгойд 2010 онд хийсэн хадны зургийн судалгааны ажлын үр дүнг энэ бүтээлд нийтэлж, археологич, угсаатны зүйч, түүхч, урлаг судлаач болон Монголын хадны зургийн дурсгалыг сонирхогч хэн бүхэнд зориулав.

63.4

Ц-96

/НУН унш-1ш/

ЭШФ Т-19248-19250



Цэрэндагва Я. **Палеолит судлалын үндэс-I** / Ред. Д.Цэвээндорж.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 173х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Түүх, Археологийн хүрээлэн).- ISBN 978-99978-0-590-4.

Энэхүү бүтээлд археологийн шинжлэх ухааны хамгийн эртний үеийг судалдаг салбар болох палеолит судлалын үүсэл, хөгжил, чулуун зэмсэг үйлдвэрлэлийн тухай ойлголт, түүний хөгжлийн чиг хандлага, багаж зэвсгийн төрөл зүйл зэргийг багтаан авч үзсэний дээр палеолитийн шинжлэх ухаантай салшгүй холбоотой эртний газарзүй, геологи, геоморфологийн олон чухал асуудлыг хөндөж гаргасан. Чулуун зэвсэг палеолит судлаач, мэргэжлийн их, дээд сургуулийн багш, оюутан, эртний түүхийг соирхон судлагч хүн бүхэнд зориулав.

63.4

Ц-96

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-19276-19278

Нүүдэлчдийн өв судлал / Эрхл. Ц.Эгиймаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 281х.- (Nomadic Heritage Studies Museum Nationale Mongoli).- ISBN 978-99929-1-499-8.



Монголын үндэсний музейгээс эрхлэн гаргадаг цуврал бичгийн энэ удаагийн хэвлэлд эртний археологийн дурсгал, булш, хадны зураг, бичээс, түүх судлалын баримтууд, угсаатан судлал, соёл урлаг судлалын эрдэм шинжилгээ судалгааны хэлэлцүүлэг, дүгнэлт, баримт бичгүүд багтсан байна.

63.5

Н-88

ЭШФ Т-20645



Алтангүл Б. **Казахын соёл, зан заншил**: Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл / Ред. Ц.Баттулга.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 108х.- ISBN 978-99973-42-05-8.

Доктор Болатын Алтангүлийн сүүлийн жилүүдэд Монгол дахь Казахуудын соёл, зан заншилын талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлийг эмхэтгэн та бүхэнд толилуулж байна. Эдгээр өгүүллийг МУИС-ийн “Аста Монголика”, “Монгол улс: орон судлал, соёлын судалгаа”, “Политологи”, “Оюуны хэлхээ” сэтгүүл, Японы угсаатны зүйн музейн эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл зэрэг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн билээ. Эдгээр өгүүллээрээ Монголын казахууд бүргэдтэй хэрхэн холбогдох болон бүргэдийн бэлгэдлийн агуулгыг нь авч үзжээ.

63.5(1)

А-48

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20988-20990

ЭДИЙН ЗАСАГ, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Бизнес судлал Х анги: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 10 дугаар ангийн сурах бичиг / С.Ариунаа, П.Баянсан, Л.Оюун ба бус.; Ред. З.Оюунцацрал, С.Батцэцэг.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 181х.- ISBN 978-99978-61-43-6.



Энэхүү сурах бичиг нь хувь хүний санхүү, хувийн бизнес гэсэн 2 бүлэгтэй бөгөөд хүүхдэд эдийн засгийн тулгуур ойлголт өгч хүн сайн сайхан амьдрах зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн чухал хэрэгсэл болох мөнгөний талаар өөрийн үзэл бодолтой болох, бизнес гэж юу болох, бизнесийн төрөл, бизнесийн шинэ санаа олох, түүнийгээ хэрэгжүүлэхийг эрмэлзэх, бизнесийн орчны шинжилгээ хийх зэрэг чадвар эзэмшихэд чухал ач холбогдолтой болжээ.

65я721

Б-47

ЭШФ Т-21031



Бизнес судлал XI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 дугаар ангийн сурах бичиг / Д.Оюунцэцэг, С.Ариунаа, С.Батцэцэг ба бус.; Ред. З.Оюунцацрал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 70х.- ISBN 978-99978-61-37-5.

Энэхүү сурах бичиг нь өрхийн санхүү, өрхийн бизнес гэсэн 2 бүлэгтэй ба өрхийн орлого, түүнийг нэмэгдүүлэх арга, өрхийн зардал, түүнийг хэмнэх боломж, өрхийн төсөв, өрхийн хуримтлал хэрхэн үүсгэх, өрхийн бизнесийн санаа, бизнесийн зээл, бизнесийн ёс зүй, бизнесийн амжилтад хүрэх арга замын тухай ойлголтыг сурагчдад өгөх ажээ.

65я721

Б-47

ЭШФ Т-21032

Батмэнд Р. **Монголын хөгжлийн бодлогын философи:** Улс төрийн эдийн засгийн ухаан холбогдох нь / Ред. Б.Даш-Ёндон.- УБ.: Тод бичиг, 2016.- 424х.- ISBN 978-99973-3-553-1.



Доктор, профессор Рэнцэнгийн Батмэндийн бичсэн "Монголын хөгжлийн философи: Улстөрийн эдийн засгийн ухаан хамаарах нь" хэмээх ганц сэдэвт эл зохиол эдүгээгийн манай Монголын нөхцөлд онцгой анхаарах хэрэгтэй болчихоод байгаа эдийн засгийн философийн сэдвийг олны анхааралд хүргэхэд чиглэгдсэн байна. Эл бүтээл салбарын эдийн засгийн онолыг судлахад тусгайлан зориулагдаагүй, харин түүний үндсэн суурь нь болсон, одоо манай Монголд улс төрийн салбарт яригдахаа больчихоод байгаа улстөрийн эдийн засгийн ухааныг, тодруулбал, философижсон (гүн ухаанжсан) эдийн засгийн онолыг судлахад зориулагдсан болно. Мөн зохиогч судалгаа, шинжилгээнийхээ дүнг үндэслэн, төр улсын маань удирдлага цаашид заавал анхаарвал зохих бодлоо тусгажээ.

65.01

Б-33

/ОУХНУС-1ш/



Монгол улс: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан-2016.- УБ., 2017.- 214х.- (Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв).- ISBN 978-99978-0-609-3.

Энэхүү тайланд аймаг бүрийн давуу болон сул талууд, хамгийн ихээр хувьсан өөрчлөгдөж буй үзүүлэлтүүд болон тулгамдаж буй асуудлыг судалж, хөгжлийн зөв сонголт хийхэд хэрэг болохуйц мэдээллийг агуулсан.

65.01(1)

М-69

ЭШФ Т-20657-20658

Улаанбаатар хот дүүргүүдийн өрсөлдөх чадварын анхны тайлан 2017.- УБ.: Түшиг дизайн ХХК., 2017.- 174х.- (Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв).- ISBN 978-99978-0-611-6.



Өрсөлдөх чадвар гэх ойлголт нь аливаа бодлого хэр оновчтой томъёологдож, түүний үр дүн хэрхэн хэрэгжиж буйг олон салбар үзүүлэлтүүдийн хүрээнд үнэлж, цаашид хэрхэн хөгжих чигээ тодорхойлоход тусалдаг. Энэ тайланд нийслэл хот болон дүүргүүдийг өөр хооронд нь харьцуулан судалж, давуу болон сул талуудыг тодорхойлж, өрсөлдөх чадварын үзүүлэлтийг гаргажээ.

65.01(1-5)

У-29

ЭШФ Т-20654-20656



Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Тунхаглалын гарын авлага: Боть-1, 2.- УБ., 2011.- (Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо).- ISBN 978-1-60815-582-8.

Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг Монгол улс 2003 онд орчуулан хэвлэж байжээ. Энэхүү гарын авлагад Нягтлан бодогчдын олон улсын холбоо (НБОУХ)-ны тухай үндсэн мэдээлэл болон 2011 оны 1 дүгээр сарын 15-нд НБОУХ-ноос гаргасан хүчин төгөлдөр бүхий Улсын Секторын Тунхаглалыг оруулсан болно.

65.052

У-31

Боть-1: Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын тунхаглалын гарын авлага, НБОУХ 2011 он.- 636х. БС-9738-9740
Боть-2: НБОУХ 2011 Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын тунхаглалын гарын авлага.- 649х. БС-9741-9743

Journal of the accounting-theory and practice Vol-1.2: Нягтлан бодох бүртгэл-онол практикийн сэтгүүл / Ред. Б.Сайнжаргал, Л.Мөнх-Очир, С.Даваасүрэн ба бус.- УБ., 2017.- 68х.- ISSN 2522-106X.



МУИС-ийн Бизнесийн сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимээс эрхлэн гаргадаг энэхүү сэтгүүлд тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчин, нягтлан бодох бүртгэл, татварын мэргэшсэн зөвлөх, аудит, банкны тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг төслийн, гадны капиталын, өөрийн капиталын мөнгөн гүйлгээдээр задлан иж бүрэн шинжилгээг хэрхэн хийх зэрэг өргөн хүрээний мэдлэг олгохоор багш, судлаачдын бүтээлүүд багтжээ.

65.052

J-80

/БС-10ш/



Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 2013.- УБ., 2014.- 187х.

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь Нягтлан бодогчдын олон улсын холбооны жинхэнэ гишүүн байгууллага бөгөөд шинээр батлагдсан стандартуудыг эх хэл дээрээ орчуулан гаргадаг билээ. Энэхүү бүтээл нь нийт мэргэшсэн нягтлан бодогчид, аудиторууд, нийт нягтлан бодогчид төдийгүй их, дээд сургууль, коллежийн оюутнуудад өөрийн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм.

65.261ц

C-32

/БС-3ш/

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэглээний тайлбар-2014 / Ерөн. хян. Л.Энх-Амгалан; Хян. Ч.Чимидсүрэн.- УБ.: Галбилэг принт, 2014.- 621х.- ISBN 978-99973-857-7-2.

Энэхүү гарын авлагад НББ-ийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс боловсруулсан 2013 оны “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт”-ыг стандарт бүрээр тайлбарлан бэлтгэж, зарим хураангуйлсан үг, түүнтэй холбоотой нэр томъёоны тайлбарыг багтаажээ.

65.261ц

C-32

/БС-3ш/



Хувьцаа ямар ашигтай вэ / С.Тулга, Б.Саруулзул, Л.Долгорсүрэн ба бус.; Хян. Б.Оюунчимэг.- УБ., 2016.- 170х.- ISBN 978-99978-4-228-7.

Хөрөнгийн зах зээл итгэлцэл дээр тогтдог бөгөөд учир нь та өөрийн мөнгийг өөр хүнд өгч хөрөнгө оруулалт хийдэг. Энэ нөхцөлд та таны мөнгийг хэр зэрэг зөв зохистой зарцуулж байгааг маш сайн мэдэж байх хэрэгтэй болдог. Таны итгэлийг ёс суртахуунгүй хэн нэгэн ажилтан эсвэл хэсэг бүлэг нөхөд алдагдуулах эрсдэлтэй. Энэ бүхний эцэст хөрөнгө оруулагчид хохирч үлддэг. Ийм учраас Монголчуудад хөрөнгийн зах зээлийн талаар бүрэн дүүрэн зөв ойлголт, суурь мэдлэг, алсын хараа өгөх зорилгоор энэхүү номыг гаргажээ.

65.262.2

X-65

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-19286-19288

Мартагдашгүй он жилүүд: Боть-2: Дурсамж / Ред. П.Бадрал.- УБ.: Бэмби сан, 2017.- 440х.


Энэхүү дурсамжийн номонд Материал техникийн хангамжийн системд ажиллаж байсан үе үеийн ахмад ажилтнуудын дурсамж, дуртгалыг түүхэн гэрэл зургийн хамт оруулсан байна.

65.40(1)г

M-27

ЭШФТ-20610





Болдбаатар Ч. ба бус. **Монголын эдийн засгийн түүхийн альманах** / Д.Түмэн-Өлзий, Б.Цэнддоо; Ред. Ц.Ариунтунгалаг, Х.Бум-Эрдэнэ, Т.Цэнд-Аюуш.- Анхны хэвл.- УБ.: Нэпко, 2014.- 270х.- (National Geographic).- ISBN 978-99962-66-93-5.

Монголын нийгмийн эдийн засгийн чадавхи, хөгжлийн бодлого болон анхны эмнэлэг, сургууль, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, банк, мөнгөн тэмдэгт, төмөр зам, холбоо харилцаа, агаарын тээвэр, дэлгүүр, худалдаа, татвар, өмчийн харилцаа, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, геологи уул уурхай, аялал жуулчлал, өмч хувьчлал, хөрөнгийн зах зээл гэх мэт эдийн засгийн бүхий л салбарын хөгжлийн түүх, өнөөгийн дэвшлийг харьцуулсан баримтат зураг, товч тодорхой тайлбартайгаар оруулсан байна.

65.9(1)г

Б-54

ЭШФ Т-20659

УЛС ТӨР, УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баатар Ч. **Тусгаар Монгол, ардчилсан төрийн төлөвшлийн асуудал** / Ред. Д.Чулуунжав, Р.Ринчинбазар.- УБ.: Бемби сан, 2016.- 254х.- (Шинжлэх Ухааны Академи. Философийн хүрээлэн).- ISBN 978-99929-2-782-3.



Энэ номонд зохиолчийн Монгол улс социализмаас ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих үеийн тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээл, мэдэхгүйн зовлонг нимгэлэх сэтгэл өвөрлөн шинэ нийгмийн улс төр, эдийн засаг, хөгжлийн бодлого, гадаад бодлого, гадаад харилцаа хийгээд засаглалын асуудлыг зөв харж, нааштай шийдвэрлэх гарц замыг олоход тус болохуйц нийтлэл, өгүүлэл, хэлсэн үгийг эмхэтгэн толилуулж байна.

66.3(1)

Б-11

ЭШФ Т-20651-20652



Монгол улсын гадаад бодлогын хөх ном-2016.- УБ.: “BCI” хэвлэлийн газар, 2017.- 129х.


Энэхүү бүтээлд Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагаа, эдийн засгийн гадаад харилцаа болон олон талт хамтын ажиллагаа, гадаад сурталчилгаа, соёлын харилцааны талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, 2016 онд болсон олон чухал үйл явдлын талаар дурьджээ.

66.4

М-69

ЭШФ Т-21033-21035

Монголын залуучууд 1911-2008: Боть-2: Түүх, цадиг, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэл / Эмхт. С.Даш; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2008.- 1099х.- ISBN 978-99929-4-258-4.




Хоёр зууныг дамжсан хөгжлийн их буухиаг өртөөлөн тээж, улс эх орны хөгжил, хүн зонихоо сайхан амьдралын төлөө залуу нас оргилсон их хүч, хөдөлмөрөө зориулсан мянга мянган залуусын ажил үйлс, тэдгээрийг удирдан зохион байгуулсан залуучуудын байгууллагын /МХЗЭ/ түүхэн замналын талаар өгүүлжээ.

66.75(1)

Д-392

ЭШФ Т-20672



Монголын залуучууд 1911-2010: Боть-3: Түүх, цадиг, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэл / Эмхт. С.Даш; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2008.- 1497х.- ISBN 978-99962-1-256-7.

Хоёр зууныг дамжсан хөгжлийн их буухиаг өртөөлөн тээж, улс эх орны хөгжил, бүтээн байгуулалтад залуу нас оргилсон их хүч, хөдөлмөрөө зориулсан мянга мянган залуусын ажил үйлс, урлаг спортын амжилтууд, тэдгээрийг удирдан зохион байгуулсан залуучуудын байгууллагын /МХЗЭ/


түүх, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэлийн талаар өгүүлжээ.

66.75(1)

Д-392

ЭШФ Т-20673

Монголын залуучууд 1921-2011: Боть-4: Түүх, цадиг, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэл / Эмхт. С.Даш; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2012.- 649х.- ISBN 978-99973-58-33-5.



Улс эх орны хөгжил, социалист бүтээн байгуулалтад залуу үеийг удирдан зохион байгуулж, манлайлан оролцож байсан /МХЗЭ/ залуучуудын төв байгууллага, тэдний салбар хороодын үүсэл, хөгжлийн үе шат, гадаад харилцаа, залуучуудын хөдөлгөөн, чуулга уулзалт, оюутны их наадамд оролцож явсан түүх, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэлийн тухай өгүүлсэн байна.

66.75(1)

Д-392

ЭШФ Т-20675



Монголын залуучууд 1921-2011: Боть-5: Түүх, цадиг, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэл / Эмхт. С.Даш; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 648х.- ISBN 978-99973-58-33-5.

МХЗЭ-ийн байгууллагыг санаачлан, үндэслэн байгуулагчид, анхны гишүүд, үе үеийн удирдлага, тэргүүлэгчид, улс төрийн зүтгэлтнүүд, Холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүсийн түүх, намтар, дурсамж, улс


төрийн хэлмэгдүүлэлт, хурлын илтгэл зэрэг МХЗЭ-ийн түүхэнд холбогдох материалуудыг эмхэтгэн оруулжээ.

66.75(1)

Д-392

ЭШФ Т-20674-20676

Монголын залуучууд 1921-2014: Боть-6: Түүх, цадиг, намтар, дурдатгал, өөрчлөлт, шинэчлэл / Эмхт. С.Даш; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- 558х.- ISBN 978-99973-2-453-5.



Монголын үе үеийн залуучууд, өсвөр үеийнхний оруулсан хувь нэмэр, амжилт бүтээлийг хэвлэлийн хуудаснаа мөнхлөн үлдээсэн Монголын залуучуудын байгууллага, Монголын пионерийн байгууллагын төв хэвлэл “Залуучуудын үнэн”, “Пионерийн үнэн” сонин болон бусад сэтгүүл, хэвлэлийн түүх, хөгжил, шинэчлэл, ахмад сэтгүүлч, идэвхитэн бичигчдийн дурсамж, дурдатгалыг эмхэтгэжээ.

66.75(1)

Д-392

ЭШФ Т-20677

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН



Кашанина Т.В. **Хууль зүйн техник** / Орч. С.Гэрэлмаа, Д.Отгончимэг, Н.Тунгалаг; Орч. Ред. Н.Лүндэндорж.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 444х.- ISBN 978-99929-67-76-8.

Хууль зүйн техник нь төрөл бүрийн эрх зүйн баримт бичгийг боловсруулах, хууль зүйн ажлыг гүйцэтгэх, дүрэм журмын талаархи мэдлэг юм. Хууль зүйн техникийг судлах нь хууль зүйн боловсролын онол практикийн хосолсон ур чадварыг эзэмших ач холбогдолтой. Энэ номонд хууль, эрх зүйн бүхий л баримт бичгийг боловсруулах арга техникийг эзэмших, ирээдүйн хуульчид мэргэжлийн алдаа гаргахаас сэргийлэхэд туслах чухал агуулгыг багтаасан байна.

67

К-31

/ХЗС-5ш/

Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: Бизнес үзүүлэх нөлөө / Эмхт. Г.Цагаанбаяр; Ред. Б.Амарсанаа, С.Батбаяр.- УБ.: Арвай Бархан, 2017.- 146х.- (Хурлын эмхтгэл).- ISBN 978-99978-0-995-7.



“Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: Бизнес үзүүлэх нөлөө” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2016 оны 9-р сарын 17-ны өдөр Япон сан, МУИС-ийн ХЗС-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан байна. Тус хурлыг “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ санаачилсан бөгөөд энэхүү номонд хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэдийн тавьсан илтгэлүүдийг эмхэтгэжээ.

67

М-69

ЭШФ Б-28150



Америкийн “Бар”-ын холбооны дүрэм, дотоод журам, төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааны журам / Орч. Н.Чимгээ; Ред. З.Сүхбаатар.- УБ.: Адмон принт, 2016.- 80х.- (“Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирм).- ISBN 978-99962-76-46-0.

АНУ-ын “Бар”-ын холбоо нь 1878 онд байгуулагдаж, 2015 оны байдлаар 416982 гишүүнтэй сайн дурын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага юм. Манай улс “Бар”-ын холбоогоо хэрхэн хөгжүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, үзэл бодлоо уралдуулж, байгаа энэ цаг үед АНУ-ын “Бар”-ын холбооны дүрэм, дотоод журам, Төлөөлөгчийн танхимын үйл ажиллагааны журмыг англи хэлнээс орчуулан нийтийн хүртээл болгож буй нь цаг үеэ олсон бүтээл болжээ.

67.3(7АНУ)

А-53

ЭШФ Т-20626-20627

Машбат О. **Үндсэн хууль:** Улстөр-эрхзүй, хяналт-тэнцэл.- УБ.: Арвайбархан, 2015.- 233х.- (“Эрх зүйт ёс” сан).- ISBN 978-99962-78-36-5.



МУИС-ийн ХЗС-ийн доктрант, судлаач О.Машбат бол Монголын шинэ үеийн үндсэн хуулийн эрх зүйчдийн томоохон төлөөлөл бөгөөд түүний туурвисан энэхүү нэг сэдэвт бүтээл бол зохиогчийн сүүлийн арав гаруй жилийн судалгааны гол үр дүн юм. Энэхүү бүтээлд нэгд, парламентын ардчилалд эрх мэдлийг хэрхэн байршуулсан байдаг вэ, хоёрт, парламентын засагт эрх мэдлийг хуваарилсан ямар зохицуулалт байдаг вэ, гуравт, Монгол улсын төрийн байгуулалт эрх мэдлийг хэрхэн байршуулсан ямар хэлбэрт хамаарах вэ зэрэг асуултанд үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс иж бүрэн хариулт өгөхийг зорьж, уг бүтээлд олонхийн болон зөвшилцлийн ардчиллын загварыг чадварлаг ашигласан байна.

67.400.1

М-32

/ОУХНУС-2ш/



Сонгуулийн үйл ажиллагаанд ашиглаж болох гэрээ: Үлгэрчилсэн загвар / Ред. Э.Батбаяр.- УБ.: ХЗҮХ., 2016.- 46х.

Сонгуульд нэр дэвшигч болон менежер, шадар туслагч, ухуулагч, хандивлагч, ажил гүйцэтгэгч, хуульч, түрээслүүлэгч зэрэг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хоорондын харилцаагаа хуулийн хүрээнд илүү тодорхой, журамлан зохицуулахад шаардлагатай 15 гэрээний загварыг боловсруулан, оруулсан байна.

67.400.5

С-56

ЭШФ Т-20628-20629

Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)-ны эрх зүй / Эмхт. Г.Цагаанбаяр; Ред. С.Батбаяр, Н.Норовсамбуу.- УБ.: Арвай Бархан, 2017.- 331х.- (Илтгэлийн эмхэтгэл).- ISBN 978-99978-1-771-6.



“Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)-ны эрх зүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2017 оны 9-р сарын 16-ны өдөр Япон сан, МУИС-ийн ХЗС, Нагоягийн их сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан бөгөөд тус хуралд хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэдийн тавьсан илтгэлүүдийг эмхэтгэн гаргаж байна.

67.412

М-69

ЭШФ Б-28154



Хувийн хэрэг: Өмгөөллийн тухай хууль 1994 / Эрхл. Д.Ганзориг, Д.Батсүх, З.Сүхбаатар.- УБ.: Адмон принт, 2015.- 143х.- (Монголын хуульчдын холбоо, “Монгол өмгөөлөгч” Хууль зүйн фирм).- ISBN 978-99973-0-687-6.

Энэ номонд “Өмгөөллийн тухай хууль” /1994/-ийн хуулийн төсөл, эрдэмтэн судлаачид, хуульч, өмгөөлөгчид, УИХ-ын эрхэм гишүүд, төрийн эрх бүхий байгууллагын санал уг эхээрээ багтаж байгаа бөгөөд, эрдэм шинжилгээ, судалгаа, өмгөөллийн үйл ажиллагааны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор уг хуулийн хувийн хэргийг УИХ-ын тамгын газарт хадгалагдаж байгаа албан ёсны эхээс нь хэвлэн нийтэлжээ.


67.75(1)

Х-64

ЭШФ Т-20589-20590

СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН. ГЭГЭЭРЭЛ

Соёл судлаачдын үндэсний X семинарын материал: 2017.05.19 / Эмхт. Т.Дорждагва, Б.Дагзмаа, Б.Мөнхжавхлан.- УБ.: Бит Пресс, 2017.- 232х.- ISBN 978-99978-58-18-4.




Монголын соёл судлалын холбооноос санаачлан “Соёл судлаачдын үндэсний семинар”-уудыг 1998, 2003, 2006-2008, 2010, 2014, 2015 онд зохион байгуулсан билээ. Энэхүү номонд Нийслэлийн Соёл, урлагийн газар үүсэн байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан семинарын материалыг мэргэжлийн багш, судлаачид болон суралцагчид, соёлын тухай сэдвийг сонирхон уншигч өргөн олонд зориулан эмхэтгэжээ.

71.0

С-52

/НУН унш-3ш/

ЭШФ Т-19307-19308



Нарантуяа Д. **Судалгааны арга зүй** / Хян. Т.Билгүүдэй, Б.Бүжинтуул.- УБ.: Адмон принт, 2017.- 135х.- ISBN 978-9996-208898.

Биднийг хүрээлэн байгаа орчлон ертөнц, хүмүүн үзэгдлийг танин мэдэх зорилго нь тэдэнтэй зохицох, сөрж даван хөгжиж, дэвжих гэсэн хүслээс үүдэлтэй бөгөөд хүмүүсийн мэдлэгийн хүрээ цагийн эргэлтээр тэлж байдаг ч ул суурьтай мэдлэг нь бодит баримтад тулгуурласан мэдлэг, туршлагаас бүрэлддэг билээ. Харин бодит баримт мэдээллийг тухайлсан аргаар, тогтсон горимын дагуу бүрдүүлдэг ба тэрхүү судалгааны арга зүйн талаар энэ номонд өгүүлжээ.

72

Н-29

/НУН унш-5ш/

ЭШФ Т-20620-20622

Эрдэм шинжилгээний бичиг №2 / Ред. Д.Дашпүрэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2013.- 122х.- (Олон Улс Судлалын Дээд Сургууль. Философи Социологи Политологийн Хүрээлэн).- ISBN 978-999732-285-2.

Олон улс судлалын дээд сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэхүү дугаарт философийн ухааны хөгжил, улс төр, нутгийн өөрөө удирдах ёс, эрх зүйн тогтолцоо, олон улсын эрх зүйн схемүүд зэрэг судлагааны өгүүлэлүүд оржээ.

72

Э-73

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20630-20631



Эрдэм шинжилгээний бичиг №3 / Ред. Д.Дашпүрэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 102х.- (Олон Улс Судлалын Дээд Сургууль. Философи Социологи Политологийн Хүрээлэн).- ISBN 978-999732-285-2.

Олон улс судлалын дээд сургуулиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт философийн метафизик, улс төрийн философи, түүх, гүн ухаан, улс төр, олон улсын эдийн засгийн харилцаа зэрэг өргөн хүрээг хамарсан судалгааны бүтээлүүд багтжээ.

72

Э-73

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20632-20633

БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ УХААН

Энхтүвшин Б. **Монголын боловсрол, иргэншил судлал I** / Ред. Б.Жадамба.- УБ.: Адмон принт, 2014.- 580х.- ISBN 978-99973-0-313-4.

Зохиолч нь даяаршлын эрин үед өөрийн улсын боловсролын тогтолцоог илүү танин мэдэх, бусад орны боловсролын тогтолцооны ололттой талыг



тодруулах, улмаар олон улсын харилцан ойлголцолд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулахыг зорьж, 1990-2009 он хүртэл 20-иод жилийн судалгааны ажилдаа тулгуурлан энэ бүтээлээ эмхэтгэжээ.

74.1

Э-66

ЭШФ Т-20653



Монголын пионерийн байгууллага: Боть-7 / Эмхт. С.Даш, Ц.Түвшинтөгс, Т.Баярсайхан; Зөвл. Л.Түдэв.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 940х.- ISBN 978-99978-1-720-4.

Уг номд монголын хүүхэд багачууд, тэдний байгууллага хөдөлгөөний талаар нам төрөөс баримталсан бодлого шийдвэр, авсан арга хэмжээ, хүүхэд залуучуудын үүсгэл санаачлага, идэвхи оролцоо, хүсэл тэмүүлэл, амьдралын туршлага, сургамжийн холбогдолтой баримт бичиг, түүхэн тэмдэглэл, дурсамж, дурдатгал, тоо баримт, ном хэвлэлийн тойм, гэрэл зураг тэргүүтэй түүхийн судалгааны баялаг материалыг нэг дор эмхэтгэн оруулсан чухал бүтээл юм.

74.27(1)

М-69

ЭШФ Т-20678-20680

ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Шагдарсүрэн Ц. **Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган:** Боть-I-III / Эрхл. Д.Заяабаатар, И Сөн Гюү; Эмхт. Б.Энхсүвд.- УБ., 2017.- (Монгол улсын их сургууль. Монгол судлалын хүрээлэн).



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж буй “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралын энэ удаагийн дугаарт Монгол улсын төрийн шагналт, ШУ-ны гавьяат зүтгэлтэн, Хүмүүнлэгийн шинжлэх ухааны доктор, профессор Цэвэлийн Шагдарсүрэнгийн эрдэм шинжилгээний өгүүллийг толилуулж байна. Энэхүү гурван боть өгүүллийн эмхэтгэлд түүний судалгааны ажлын явцдаа бичиж хэвлүүлж байсан болон хараахан хэвлэгдээгүй эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, олон нийтэд зориулсан судалгааны чанартай тэмдэглэлээс хамруулжээ.

80+81.2М

Ш-15

Б. 1: Монгол хэл шинжлэл, Алтай судлал.- 552х.- ISBN 978-99978-58-30-6.

ЭШФ Т-20907-20909

Б.2: Нийгэм, соёл, эхбичигийн судалгаа, угсаатны зүй.- 323х.- ISBN 978-99978-58-30-6.

ЭШФ Т-20910-20912

Б.3: Судалгааны тэмдэглэл, нийтлэл, бодол эргэцүүлэл.- 246х.- ISBN 978-99978-58-30-6.

ЭШФ Т-20913-20915



Чоймаа Ш. **Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган:** Боть-I, II / Эрхл. Д.Заяабаатар; Эмхт. Э.Мөнх-Учрал, Э.Жаргалмаа.- УБ., 2017.- (Монгол улсын их сургууль. Монгол судлалын хүрээлэн).

МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цуврал ном гаргаж байгаа билээ. Цувралын энэ удаагийн дугаарт Монгол улсын төрийн шагналт, Ардын болон гавьяат багш, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор Шаравын Чоймаагийн эрдэм шинжилгээний өгүүллийг эмхэтгэжээ. Тус цувралаар Ш.Чоймаагийн монгол хэл, соёл, ёс заншил, шишин шүтлэг, үсэг бичиг, түүхэн сурвалж, Алтай судлалын чиглэлээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүллийг бүрэн эхээр нь уншигч олонд хүргэж байна.

80+81.2M

Ч-75

Б.1: Монгол сурвалж судлал.- 384х.- ISBN 978-99978-1-693-1.

ЭШФ Т-20922-20924

Б.2: Монгол хэл, бичиг, соёл судлал.- 416.- ISBN 978-99978-1-693-1.

ЭШФ Т-20925-20927

Базаррагчаа М. **Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган:** Боть-I-IV / Эрхл. Д.Заяабаатар; Эмхт. Б.Мөнгөнцэцэг, Б.Одончимэг, М.Энхжаргал.- УБ., 2017.- (Монгол улсын их сургууль. Монгол судлалын хүрээлэн).



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж буй “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралын энэ удаагийн дугаарт Монгол улсын ШУ-ны гавьяат зүтгэлтэн, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор Мөнхжаргалын Базаррагчаагийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулганыг өргөн барьж байна. Профессор М.Базаррагчаа нь монгол хэлний авиа, үг, бүтээвэр, өгүүлбэр, эх судлалын бүхий л түвшнээр судалгаа хийж, олон арван бүтээл туурвисан бөгөөд Монгол хэлний түүхэн бүтээвэр, үгийн гарал судлалын талаар бичсэн бүтээлээрээ дэлхийн Монгол судлалд байр сууриа эзэлсэн шилдэг эрдэмтэн билээ. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган нь Монгол хэл бичгийг сонирхон судлагч, суралцагч хүн бүхний гарын авлага болох ажээ.

81.2M

Б-16

Б.1: Монгол хэлний авиалбар судлал.- 466х.- ISBN 978-99978-58-34-4.

ЭШФ Т-20928-20930

Б.2: Монгол хэлний бүтээвэр судлал.- 677х.- ISBN 978-99978-58-34-4.

ЭШФ Т-20931-20933

Б.3: Монгол хэлний үг судлал.- 602х.- ISBN 978-99978-58-34-4.

ЭШФ Т-20934-20936

Б.4: Монгол хэлний өгүүлбэр судлал.- 452х.- ISBN 978-99978-58-34-4.

ЭШФ Т-20937-20939



Төмөртоого Д. **Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган: Боть-I, II / Эрхл. Д.Заяабаатар; Эмхт. Б.Энхсүвд, Б.Пүрэвдэлгэр.- УБ., 2017.-** (Монгол улсын их сургууль. Монгол судлалын хүрээлэн).

“МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралаар Монгол улсын ШУ-ны гавьяат зүтгэлтэн, хэлшинжлэлийн ухааны доктор, профессор, академич Домийн Төмөртоогогийн эрдэм шинжилгээний өгүүллийн чуулганыг өргөн барьж байна. Тэрбээр монгол хэлний түүхэн хэл зүй, Алтай судлал, үсэг бичгийн судлалаар дэлхийн Монгол судлалын хүрээнийхэн хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл туурвидаг билээ. Түүний бүтээлүүд Монгол хэл судлалын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг бөгөөд тухайн сэдэвт холбогдох бүтээлийг цөлбөн үзэж жишээ, баримтаар баталж нотлохын зэрэгцээ эрдэм шинжилгээний товч тодорхой найруулгаар бичихийг чухалчихдаг байна.

81.2М

T-58

Б.1: Монгол хэлний түүхэн хэл шинжилгээний судалгаа.- 430х.- ISBN 978-99978-58-31-3. ЭШФ T-20916-20918

Б.2: Монгол хэл шинжилгээний судалгааны түүхээс.- 262х.- ISBN 978-99978-58-31-3. ЭШФ T-20919-20921

Монгол хүний нэрийн тайлбар толь: Кирилл-монгол тайлбартай / Ш.Чоймаа, Д.Бүрнээ, М.Баярсайхан ба бус.- УБ.: Соёмбо пресс, [2017].- 826х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол хэл Соёлын Сургууль).- ISBN 978-99962-2-241-2.




Урьд гарсан толь бичгүүдэд хамгийн түгээмэл нэрсүүдийг хамруулсан байсныг аль болох нэмэгдүүлэн бүрэн хамруулахыг хичээн, үг нэг бүрийн утгын гарлыг шүүрдэн нягталж, тодруулан 30000 гаруй нэрийг хамруулан эмхтгэжээ.

81.2М-3

M-69

/НУН унш-7, ГНОФ-5/

ЭШФ T-19273-19275



Дашдондов Ц. **Монгол-Англи өвөрмөц хэлц, хэллэгийн их гарын толь / Хян. С.Алтанцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 904х.- ISBN 978-99962-3-922-9.**

Аливаа хэлний үг зүй, утга зүй, найруулга зүйн хамгийн олон онцлог шинжийн цогц бүрдэл гэвэл зүйр цэцэг үг, сургаал үг, хэлц, хэллэг юм. Хэлэнд адил бичлэгтэй, ижил утгатай бас нэгийг хэлээд нөгөөг ойлгуулдаг өвөрмөц хэллэг их байдаг болохоор түүний мөн чанарыг ухаарахгүй бол бэлчээрийн хэл сурсан ч гэсэн оюуны хэл мэдэхгүйтэй ижил юм. Сурах, мэдэх хоёрын ялгаа үүн дээр л гардаг буюу Монгол хэлээр "ам" гээд биччихсэн байхад хүний ам юм уу, уулын ам юм уу, савны ам юм уу, хэл амын ам юмуу ер алийг нь гэхэд хэцүү шиг л тийм

маягийн англи үгийн утгын гүнд нэвтрүүлэхийн тулд сэтгүүлч, эх хэлний шинжээч Ц.Дашдондов энэхүү толийг бүтээжээ.

81.2М-4

Д-39

/НУН унш-4, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28133-28135

Мөнхсайхан Ж. **Монгол хэлний цөм хөтөлбөр 6, 7 анги:** Жилийн хөтөлбөр, нэгж хичээлийн хөтөлбөр, ээлжит хичээлийн хөтөлбөр / Ред. Ц.Өнөрбаян.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 202х.- ISBN 978-99962-718-54.



Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хүүхдийн бие даан суралцах үйлийг дэмжих, хүүхэд бүрийн чадварыг хөгжүүлэх, эх хэлнийхээ баялаг сангаас хүртэн, яриа, бичигтээ зүй зохистой хэрэглэх ухамсар төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгыг багтаасан.

81.2М-922

М-816

ЭШФ Т-20964-20966



Япон хэлний унших бичиг / Эмхт. орч. Д.Үнэнбат, Л.Оюун; Япон хэлний ред. С.Бадрал; Монгол хэлний ред. Л.Дорждэрэм.- УБ., 2016.- 256х.- (Эхлэн суралцагч нарт зориулав).- ISBN 978-99973-73-53-3.

Тус номонд гадаад хэл суралцагчийг уйдаахгүй, сонирхолтой, япон хэл сурах тэмүүллийг бадраах үүднээс орос, япон зэрэг орны гадаад хэлний сургалтын хэрэглэгдэхүүнд багтсан богино хэмжээний өгүүлэл, үлгэр, мэдлэг олгох эх сэдвүүдийг эмхэтгэн эхлэн суралцагч нарт зориулан

орчуулгатай оруулжээ.


81.2Яп

Я-70

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28111-28113

Монгол тууль-1 / Ред. Д.Цэрэнсодном.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 306х.- ISBN 978-99962-2-562-8.




Тууль хайлах Монгол уламжлалд аливаа тууль эхлэхийн өмнө заавал Алтай, Хангайгаа магтдаг заншил тогтсон байдаг. Тэрхүү ардын зан үйлийн дагуу "Монгол тууль" цувралд "Алтай, Хангайн магтаал"-аар эхлүүлж буй бөгөөд халх туулийн жишээ болгон "Алтан гургалдай хаан" тууль, ойрад туулийн жишээ болгон "Наран хаан хөвүүн" туулийг тус тус эмхэтгэн оруулсан байна. Мөн уг магтаал болон туулийг хэрхэн хайлсан байдлыг үзүүлсэн соронзон бичлэгийг хавсаргажээ.

82.3(1)-6

М-69

ЭШФ Т-19319-19320

УРАН ЗОХИОЛ



Монголын нууц товчоо: Түгээмэл эх.- УБ.: Хүслийн өнгө, 2015.- 73х.- ISBN 978-99973-937-1-5.

Залуу уран бүтээлч Р.Батцэнгэлийн "Монголын нууц товчоо"-ны Түгээмэл эхийн дэд дэвтэр "Эсгий туургатныг нэгтгэж Их Монгол улсыг байгуулсан нь" хэмээх удаах бүтээл уншигч та бүхний гар дээр очиж байна. Р.Батцэнгэл түмэн олонд ойлгомжтойг бодолцон академич Ц.Дамдинсүрэн гуайн орчин цагийн монгол хэлнээ хялбаршуулан буулгасан "Монголын Нууц Товчоон"-г унших эх болгон зураг дүрслэлийг нь Монголын үе үеийн археологич, түүхч эрдэмтдийн судалгаа шинжилгээний үр дүнд илэрч олдсон түүхэн эх сурвалжийн мэдээ баримт, XIII зууны үеийн хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан гэр, орон сууц, дээл хувцас, гэзэг үс, ёс заншил, аж ахуй, цэргийн зэр зэвсэг зэрэг бүхий л хэрэгсэлүүдийг түүхэн олдвор эд юмсаас сэдэвлэн аль болох бодит байдлаар харуулахыг зорьжээ.

84(1)3

М-69

ЭШФ Т-19317-19318

Пүрэв С. Бороотой зуны нүүдэл: Туужууд.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 339х.- ISBN 978-99973-3-500-5.

МУ-ын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч С.Пүрэвийн "Бороотой зуны нүүдэл" хэмээх энэхүү ном нь 2 бүлэгтэй бөгөөд "Бөх Бэлгүтэй", "Тэнгэрийн хаяанд хоёулаа", "Хайду хааны танхил буюу Хотолон", "Шандугийн шар тууж", "Аргагүй амраг", "Бороотой зуны нүүдэл", "Бүсгүй хөрөг" зэрэг туужууд багтсан байна.




84(1)-44

П-91

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28097-28098



Пүрэв С. Хээрийн талд адуу янцгаана: Өгүүллэгүүд.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 320х.- ISBN 978-99973-3-501-2.

МУ-ын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч С.Пүрэвийн "Хээрийн талд адуу янцгаана" түүвэрт "Тэнэгийнхэн", "Өндөрт нисэх томилолт", "Бороотой шөнийн бодол", "Нялх ботгоны хөрөг", "Пийвны мухлагт", "Бусдын үүрэнд жаргамай", "Хөх тэнгэрийн орон", "Амраг зүгийн тэнгэр", "Сүнс аргадагч", "Үүрд ганцаар жаргана"

зэрэг 100 гаруй өгүллэг орсон байна.

84(1)-44

П-91

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28095-28096

Есенин С. **Аяа, миний амин хайртай Орос орон мину...** / Орч. Д.Бор; Хян. Л.Дашням.- УБ.: Хөх судар принтинг, 2015.- 200х.- ISBN 978-99962-861-9-3.

Сергей Есенин бол Оросын уран зохиолд өөрийгөө илт харагдахуйцаар тунхаглаж чадсан, өөрийн үгээ өөрийнхөөрөө л хэлдэг, омголон танхай найрагч юм. Түүний олон шүлгийг манай шүлэгчид орчуулсан бөгөөд яруу найрагч Д.Борын орчуулсан энэхүү ном нь орос Есениныг өөрөөс нь булаан авч, монгол шүлэгч болгожээ. Уг номын шүлгүүдийг хадмал орос эхтэй нь зэрэгцүүлэн оруулжээ.



84(2Орос)-5

Е-74

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28087-28088

УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ



Батсайхан Ц., Энхбаяр Б. **Уламжлалт ган, төмөр урлалын шилдэг бүтээлүүд.**- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 241х.- ISBN 978-99962-3-840-6.

Төв Азийн нутагт Монгол үндэстэн үүсэж, оршин тогтносон цаг үеэс амьдрал ахуйдаа хэрэглэх эд зүйлс, зэвсэгээ төмрөөр хийж, энэ нь түүхийн цаг хугацааны уртад улам боловсронгуй болж, хар төмөр, зэс, гууль, алт, мөнгөөр ахуйн хэрэглээ, гоёл чимэглэл, цэргийн зэр зэвсэг зэрэг бүхий л хэрэглээнд металлыг өргөнөөр хэрэглэснээр, уран дархчуудын ур ухаанаа шингээж хийсэн эд зүйлсийн ур хийц нь улам нарийсч, урлаг болтлоо хөгжсөн түүхийг гэрчлэх эд зүйлсийн тоймыг энэ номонд өнгөт зураг болон монгол-англи тайлбартайгаар оруулсан сонирхолтой бүтээл болжээ.

85.125(1)я6

Б-34

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-19262-19264

Оюунжаргал Р., Цогбадрах М. **Сонгодог хөгжим:** Хүүхэд залууст зориулсан лавлах ном.- УБ.: Гэрэл Пресс, 2017.- 243х.- ISBN 978-99978-0-859-2.

Энэхүү номонд XVII зуунд төрж, тухайн үеийн Европын урлагийн хөгжлийн илэрхийлэл болсон барокко хэв маягаар туурвиж байсан Италийн суут хөгжмийн зохиолч А.Вивальдигаас эхлээд XX зууны эхэнд төрсөн алдарт Д.Шостакович хүртэлх 32 суу билэгт хөгжмийн зохиолчдын намтар, уран бүтээлийн дээж товчоон, амьдрал, бүтээлийн тухай өгүүлнэ. Уг бүтээлээр өгжим бүтээл нь хамгийн өргөн тархсан хамгийн их сонсдог тоглодог өөрөөр хэлбэл хамгийн сайн судлагдсан хөгжмийн зохиолчдоор дамжуулж хүүхэд залууст сонгодог хөгжмийн тухай ойлгуулан таниулахыг зорилоо.



85.31я2

О-63

/НУН унш-3ш/

ЭШФ Т-19303-19304



Бэхбат Б. **Нүүдэлчин монголчуудын ахуйн соёл**: Нүүдэлчдийн соёл Монгол бүжиг.- УБ., 2016.- 120х.- ISBN 978-99962529-90.

Монгол уламжлалт соёл, өдөр тутмын ахуй амьдрал зан үйлээсээ үүсэн гарсан Монгол бүжгийн язгуур хөдөлгөөний элементүүд нь Монгол соёлын өвөрмөц илрэл болоод зогсохгүй эрүүл аж төрөхийн нэг үндэс болохыг энэ номонд тодотгон тодорхойлсон байна.

85.32(1)
Б-96

ЭШФ Т-20607-20609

Жэйнс К.Х. ба бус. **Аугаа уран зургууд** / И.Чилвэрс, И.Зачэк; Орч. Т.Ариунсанаа; Ред. Б.Цэнддоо, Л.Амарсанаа, Б.Болдбаатар.- УБ.: Нэпко, 2013.- 256х.- ISBN 978-99962-66-84-3.



Хүн төрөлхтний түүхэнд тодрон үлдсэн аугаа уран бүтээлчдийн гайхамшигт бүтээлүүдийн нэгэн цомог болох энэхүү бүтээлд зураачийн намтар, зураг бүтсэн түүх, судлаачийн ажиглалт, шинжлэн дүгнэсэн тайлбар сэлтийг хавсаргасан нь урлаг судлаач, уран бүтээлчдийн ширээний ном болох төдийгүй уран зураг анхлан сонирхогчдод урлагийн бүтээлийг ойлгох, шимтэн сонирхох, гоозүйн таашаал авахад туслах багш-хөтөч болох нэгэн цогц цомог болжээ.

85.32(1)
Б-96

/НУН-3ш/

ЭШФ Т-19331-19332

ШАШИН. ШИД ТАРНИ. ЧӨЛӨӨТ СЭТГЭЛГЭЭ



Гантуяа П. **XVI-XX зууны Монголын сүм хийд, эрдэмт мэргэд** / Ред. Н.Бэгз, Д.Хоролбат.- УБ.: Соёмбо принтинг, 2015.- 214х.- ISBN 978-99973-74-87-5.



Монголд Бурханы шашин дэлгэрч, 1578 онд Богд Зонховагийн урсгал орж ирснээр тал нутагт олон зуун сүм хийд байгуулагдаж, 1918 оны байдлаар 115 000 лам хуврагатай болсон гэх тоо баримт байна. Энэ сүм хийдүүдийн нэр, байгуулагдсан газар, лам хуврагийн тоо, хутагт, гэгээнтэн, эрдэмтэн мэргэдийн эрдмийн зэрэг цол, мэргэжлийн чиглэл, бүтээл туурвил зэргийг судалгаанд үндэслэн нарийн тоо баримттайгаар эмхэтгэн хэвлүүлжээ.

86.35(1)
Г-23

/НУН унш-3ш/

ЭШФ Т-20900-20901

Дэн Ариэли. **Бодлогогүй сонголтын сэтгэхүйн нууц** / Орч. П.Увш, У.Батцоож, У.Дэлгэрбат.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 295х.- ISBN 978-99978-1-326-8.



Хүн бүр л амьдралдаа цаг хором бүр шийдвэр гаргах, сонголт хийх шаардлагатай тулгардаг. Энэ ном нь бодлогогүй сонголтын талаарх сонирхолтой агуулга, шинжлэх ухаанч арга зүйгаас гадна Америкийн болон барууны орнуудын соёл, нийгмийн амьдралтай холбоотой олон жишээн дээр тайлбарлан, бидний шийдвэрт нөлөөлдөг далдын хүчний нөлөөг амьдралдаа хэрхэн зөв ашиглах, хүн бүрт тулгардаг эдийн засгийн сонголтыг ойлгоход туслах гүнзгий агуулгатай юм.


86.42

A-75

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28114-28115

ГҮН УХААНЫ ШИНЖЛЭХ УХААН



Прехт Р.Д. **Би хэн бэ? Тийм гэвэл хэдэн Би вэ?** / Орч. С.Молор-Эрдэнэ, Л.Алтангэрэл, Б.Батцэнгэл ба бус.- 2 дахь хэвл.- УБ.: Монсудар, 2015.- 376х.- ISBN 978-99973-1-029-3.


Философийн асуудлуудыг мэргэжлийн хүмүүс нь олон нийтэд зориулж энгийн хэллэгээр цаг үетэй холбон бичдэг болсон энэ цаг үед Германы философич, доктор Давид Прехт энэхүү номыг бичжээ. Энэхүү бүтээл нь олон улсад нэрд гарч орчин үеийн философийн болон хүний ухааны талаар шинэ мэдээлэл өгч, мэргэжлийн олон салбарыг нэгтгэж, хүний тухай өнөөдрийг хүртэл мэдэж авсан танин мэдэхүйн асар олон сэдвийг хураангуйлан, уншигчдад зүг чиг гаргаж, тус болохуйц болжээ. Тэр адал явдалтай амьдрал болон амьдралд юу бололцоотой, юу бололцоогүй тухай наргиантай, тоглоом шоглоомтойгоор бодох боломжийг уншигчдад өгөх юм.

87.3

П-73

/ОУХНУС-2ш/

Карнеги Д. **Leadership mastery**: Өөрийн болоод бусдын хүчийг төгөлдөршилд чиглүүлэх нь / Орч. Т.Төртүвшин; Хян. Э.Чинзориг; Ерөн. ред. Б.Оюунчимэг; Ред. Б.Энхболд, Г.Ашиг.- УБ.: Карьер Эйд, 2016.- 270х.- ISBN 978-99973-3-200-4.



Дэйл Карнегийн "Найз нөхдөө хэрхэн өөртөө татаж, бусдад нөлөөлөх вэ" хэмээх цагийг эзэлсэн алдартай номын дараагаар орох "Манлайллын мастер" хэмээх энэхүү номонд бизнес, урлаг, спорт болон боловсролын салбарын шилдэг манлайлагчидтай хийсэн ярилцлагыг багтаажээ. Өөрчлөлт асар хурдацтай явагдаж байгаа энэ эрин зуунд ихэнх зүйл цахим хэлбэрт шилжиж, хүмүүсийн

харилцаа болон манлайллын ур чадвар алдагдсаар байна. Манлайллын мастер номыг уншсанаар та өөрийн хүч чадлаа таньж мэдэн эдгээр үр дүнтэй аргуудыг эзэмших болно.

87.7

K-21

/ОУХНУС-7ш/



Намжил Т. **Харилцааны ёс журам**: Орон орны харилцааны ёс журмаас суралцагчдад зориулав.- УБ.: Битпресс, 2014.- 152х.- ISBN 978-999-73-67-13-6.

Монгол хүний зайлшгүй мэдэх шаардлагатай Монголчуудын харилцааны уламжлалт ёс, заншлын талаар онолын мэдлэг өгөхийн зэрэгцээ эдгээр нь амьдрал дээр хэрхэн хэрэглэхэд туслах, бусад орнуудад ямар онцлогтой байдаг, тэр улс үндэстнүүдийн сэтгэл зүйн онцлог, харилцааны ёс журмын

талаар анхаарах, мэдвэл зохих мэдээллийг багтаажээ.

87.7

H-25

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28128-28129

СЭТГЭЛ СУДЛАЛ

Клиник практикт хэрэглэх аргачлалууд / Орч. Б.Туяа; Хян. Т.Цэндсүрэн, Х.Өлзийтунгалаг.- УБ., 2017.- 274х.- ISBN 978-99962-2-087-6.

Хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн онцлог, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн сэтгэл зүйн уур амьсгалыг үнэлэхэд клиник практикт өргөн хэрэглэдэг үнэлгээний багц аргачлалыг монгол хэлнээ хөрвүүлэн толилуулж байна. Клиник практикт өргөн хэрэглэдэг эдгээр аргачлалыг Монголын нөхцөлд өмнө нь хэрэглэсэн туршлага хуримтлагдаагүй, нотолгоонд суурилсан практик бага учраас Монгол хүүхдийн сэтгэлзүй, Монгол гэр бүлийн онцлогт зохицуулан хэрэглэх нь зүйтэй юм.

88.5в7

K-49

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-19289-19291



Сандберг Ш. **Өөдөө тэмүүл**: Эмэгтэйчүүд, ажил хэрэг, манлайлах хүсэл зориг / Орч. Д.Ганзориг, Б.Номин, М.Өлзийхутаг, Э.Болормаа; Ред. Х.Уртаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 221х.- ISBN 978-99973-2-472-6.

Зохиогч энэхүү номондоо эмэгтэйчүүдийн удирдах албан тушаалд хүрэх зам яагаад мухардсан талаар гүнзгий судлан бичиж, өөрийгөө бүрэн дайчлах замаар энэ байдлаас хэрхэн гарч болохыг үзүүлээд, эмэгтэйчүүдийг хүсэл тэмүүлэлтэй, манлайлах амбицтай байхад уриалан дууджээ. Зохиогч эмэгтэй хүний амьдралыг тойрсон олон асуудлын талаар, тэр дундаа эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголт, уламжлалт хандлагуудын талаар өгүүлэхдээ өөрийн туулсан замнал, алдаа оноог төрөл бүрийн судалгаа, тоо баримтуудтай хослуулан бичсэн байна.


Энэ номоос та карьераа хэрхэн амжилттай удирдах, ар гэрээ ажил карьертайгаа хэрхэн хослуулж явах, ажлын байранд болон ар гэртээ эмэгтэйчүүдийг хэрхэн дэмжиж болохыг, энэ нь эргээд ямар ач холбогдолтойг эрчүүдэд тод томруунаар үзүүлжээ.

88.52+66.74

C-30

/ОУХНУС-3ш/

Сарантуяа Г. ба бус. **Сэтгэц оношилгоо**: Сэтгэл судлалын ангийн оюутнуудад зориулсан сурах бичиг / Б.Туяа, Д.Цогзолмаа.- 2 дахь хэвл.- УБ.: Жиком Пресс, 2017.- 312х.- ISBN 978-99978-0-736-6.



Их, дээд сургуулийн сэтгэл судлалын ангийн оюутнуудад зориулсан энэхүү сурах бичиг нь сэтгэл судлалын шинжлэх ухааны салбар болох сэтгэц оношилгооны судлах зүйл, судалгааны аргууд, салбарууд, практик сэтгэл судлаачийн үйл ажиллагааны хүрээ, нийгэм-ёс зүйн зарчмуудыг багтаахын зэрэгцээ хүний нас, хөгжлийн онцлогтой уялдуулан сэтгэц оношилгоог зохион байгуулах асуудлыг агуулсан байна. Мөн сэтгэц оношилгоонд ихэд хэрэглэгддэг судалгааны зарим арга, арагчлалыг багтаажээ. Энэхүү ном нь сэтгэл судлалын ангийн оюутнууд болон судлаачид, сэтгэл зүйчид, сэтгэл судлалыг сонирхогч хүн бүрт зориулагдсан болно.

88.6я73

C-33

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-19292-19294

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ



Земноводные Монголии / С.Л.Кузьмин, Е.А.Дунаев, Х.Мөнхбаяр и др.; Отв. ред. С.Л.Кузьмин.- М.: КМК изд., 2017.- 302с.- (Биологический ресурсы и природные условия Монголии. Труды Совместной Российско-Монгольской комплексной биологической экспедиции).- ISBN 978-5-9908941-8-1.


Обобщены все имеющиеся данные о земноводных, обитающих в государстве Монголия. Описываются история изучения земноводных и пресмыкающихся (включая традиционные представления Монголов о них), даны сведения по биогеографии и экологии земноводных, сокращению их популяций и проблемам охраны. Даны ключи для определения взрослых и личинок.

28.693.33(1)

З-51

ЭШФ Б-11200-11201

Баяртсайхан Н. **Государственное регулирование экономики**. - Берлин: Лап Ламперт, 2017.- 196х.- ISBN 978-3-330-33380-2.




В настоящей монографии на примере Монголии отражены проблемы формирования системы государственного регулирования экономики в условиях социально-экономической трансформации, рассмотрены

теоретические основы и функции такого регулирования, показано развития рыночных отношении в условиях преобразования собственности, отмечена необходимость усиления регулирующего воздействия государства, изучены возможности усиления форм и методов государственного регулирования экономики и активизации функций бюджетно-налоговой системы в Монголии, сделаны конкретные выводы, на основе которых высказаны предложения по совершенствованию методов денежно-кредитного регулирования социально-экономических процессов. Для интересующихся указанной проблематикой читателей.

65.050

Б-34

ЭШФ С-88757



Mongolia: Provincial competitiveness report 2016.- UB., 2017.- 214p.- ISBN 978-99978-0-608-6.

The policy and competitiveness research center is presenting you the fifth provincial competitiveness report which compares and ranks the competitiveness of all 21 provinces according to over 180 criteria. Good quality of life is a priority for every country. Therefore, the government actions should be backed by reliable research findings in order to improve the quality of life of every

citizen.

65.01(1)

М-81

ГФ 19310-19311

Ulaanbaatar city: The first district competitiveness report 2017.- UB.: Tushig Design, 2017.- 174p.- ISBN 978-99978-0-610-9.


A new era of urbanization has been taking place in Mongolia since the 1990s, when the country start-ed transitioning from a centrally planned economy to a free market economy. Economic, social, industrial and business environ-ments are more concentrated in the cities, resulting in a great dispar-ity between urban and rural areas, which in turn is influencing people's choices on where to live.

Ulaanbaatar has grown to become the economic and social development center of Mongolia. The economic Policy and Competitiveness research center has taken the initiative to study the current development level of the capital city. The competitiveness of the districts of Ulaanbaatar have been analysed according to five main factors: quality of life, living environment, safety and security, governance and economic performance-altogether comprising over 150 individual criteria.

65.01(1-5)

U-33

ГФ 19308-19309





Языковые проблемы перехода через культуру: Материалы международной научно-практической конференции / Гл. ред. П.П.Дашинимаева.- Улан-Үдэ: Изд-во Бурят.гос.ун-та., 2017.- 404с.- (Бурятский Государственный университет. Монгольский Государственный университет).- ISBN 978-5-9793-1072-5.

В сборнике представлены статьи участников международной научно-практической конференции “Языковые проблемы перехода через культуру”, организованной Институтом филологии и массовых коммуникаций Бурятского государственного университета и Центром иностранных языков Монгольского Государственного университета. Научные труды посвящены актуальным проблемам современной теории и методики преподавания иностранных языков. Сборник предназначен для научных работников, преподавателей, аспирантов и студентов.

81.2

Я-41

ЭШФ Б-11220-11221